



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын захиргааны
2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн
аудит

Аудитын код: ОРА-2021/06/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2021 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70358033 Цахим хаяг:
narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: В.Жавзмаа

Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3.Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	14
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7. Шилэн дансны мэдээлэл	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	18
Аудитын зөвлөмж	18
4. Менежментийн захидал	19

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.02.25 № 29

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Д.ЦОЛМОН ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	21,278,569.25	16,466,160.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,120,700.00	2,748,700.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	6,120,700.00	2,748,700.00
3121	Төгрөг	6,120,700.00	2,748,700.00
31211	Төрийн сангийн харилцах	6,120,700.00	2,748,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	15,157,869.25	13,717,460.00
351	Түүхий эд материал	476,760.00	908,160.00
35110	Тусгай зориулалттай материал	476,760.00	908,160.00
354	Хангамжийн материал	14,681,109.25	12,809,300.00
35410	Бичиг хэргийн материал	4,554,059.25	2,471,200.00
35420	Аж ахуйн материал	3,283,800.00	3,589,850.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	672,000.00
35470	Бусад хангамжийн материал	6,843,250.00	6,076,250.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	43,026,190.25	45,195,727.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	43,026,190.25	45,195,727.74
392	Биет хөрөнгө	42,989,523.43	45,195,727.74
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	351,254,912.06	352,733,212.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	-
		320,410,756.05	317,038,817.78
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	66,691,629.67	49,783,425.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-54,546,262.25	-40,282,091.54
39301	Программ хангамж	25,270,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-25,233,333.18	-880,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	64,304,759.50	61,661,887.74
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	64,304,759.50	61,661,887.74
51	Засгийн газрын хувь оролцоо	64,304,759.50	61,661,887.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	190,706,338.05	190,706,338.05
51101	Өмч: - төрийн	190,706,338.05	190,706,338.05
512	Хуримтлагдсан үр дүн	-	-
		127,777,505.26	129,120,621.64
51210	Өмнөх үеийн үр дүн	-	-
		127,777,505.26	126,477,749.88
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-2,642,871.76
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,375,926.71	76,171.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	64,304,759.50	61,661,887.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,069,586,938.13	955,274,224.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	632,871,519.13	565,978,471.00
120	Нийтлэг татварын бус орлого	632,871,519.13	565,978,471.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	626,750,851.70	565,978,471.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	146,829,239.00	69,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	458,192,912.70	483,610,471.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	21,728,700.00	13,368,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	156,091,119.00	48,435,053.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	280,624,300.00	340,860,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	94,161,719.00	29,942,883.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,829,239.00	19,501,383.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	87,232,480.00	10,441,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	51,796,100.00	11,396,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	51,796,100.00	11,396,100.00
1330	Төсвийн захирагчдаас	10,133,300.00	7,096,070.00
133003	Хөрөнгийн	10,133,300.00	7,096,070.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,071,585,056.20	957,917,095.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,071,585,056.20	957,917,095.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	446,371,389.51	362,199,710.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	212,809,918.97	246,701,398.54
210101	Үндсэн цалин	135,704,459.43	160,809,742.15
210102	Нэмэгдэл	60,682,571.00	59,203,359.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,345,000.00	17,551,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,077,888.54	9,136,897.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,599,006.04	31,713,377.50
210201	Тэтгэврийн даатгал	18,185,243.46	21,719,318.11
210202	Тэтгэмжийн даатгал	2,139,440.79	2,555,214.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,673,152.74	1,983,691.26
210204	Ажилгүйдлийн даатгал	418,288.19	495,926.80
210205	Эрүүл мэндийн даатгал	4,182,880.86	4,959,227.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,510,000.00	10,009,642.66
210301	Гэрэл, цахилгаан	5,238,279.32	3,447,900.27
210302	Түлш, халаалт	2,868,715.61	2,900,700.00
210303	Цэвэр, бохир ус	1,432,605.07	1,706,142.39
210304	Байрны түрээс	41,970,400.00	1,954,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,939,091.87	25,747,329.25
210401	Бичиг хэрэг	11,409,691.87	10,740,429.25
210402	Тээвэр, шатахуун	3,160,000.00	9,001,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	505,700.00	444,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	863,700.00	1,117,250.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	4,444,450.00
2105	Нормативт зардал	00.00	396,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	396,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	916,300.00	5,618,100.00
210604	Урсгал засвар	916,300.00	5,618,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,604,500.00	5,395,300.00
210702	Дотоод албан томилолт	1,604,500.00	5,395,300.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,269,560.00	2,334,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	721,060.00	1,785,750.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	346,500.00	346,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	202,000.00	202,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	135,723,012.63	34,284,312.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	89,827,673.00	13,961,849.88
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,180,043.63	20,322,462.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	625,213,666.69	595,717,385.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,043,751.00	29,895,618.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,703,505.00	5,307,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,340,246.00	24,588,018.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	147,723.99	1,663,056.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	147,723.99	1,663,056.08
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	458,192,952.70	484,760,411.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	458,192,952.70	484,760,411.34
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	146,829,239.00	79,398,300.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	146,829,239.00	69,000,000.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	10,398,300.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-1,998,118.07	-2,642,871.76
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-1,998,118.07	-2,642,871.76

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,042,970,938.13	938,641,514.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	614,485,319.13	552,610,471.00
120	Нийтлэг татварын бус орлого	614,485,319.13	552,610,471.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	608,364,651.70	552,610,471.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	146,829,239.00	69,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	461,535,412.70	483,610,471.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	428,485,619.00	386,031,043.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	280,624,300.00	340,860,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	94,161,719.00	29,942,883.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,829,239.00	19,501,383.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	87,232,480.00	10,441,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	51,796,100.00	11,396,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	51,796,100.00	11,396,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,903,500.00	3,831,360.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,903,500.00	3,831,360.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,038,407,170.70	930,525,514.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,038,407,170.70	930,525,514.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	411,290,004.01	330,976,768.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	212,809,918.97	246,701,398.54
210101	Үндсэн цалин	135,704,459.43	160,809,742.15
210102	Нэмэгдэл	60,682,571.00	59,203,359.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,345,000.00	17,551,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,077,888.54	9,136,897.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,599,006.04	31,713,377.50
210201	Тэтгэврийн даатгал	18,185,243.46	21,719,318.11
210202	Тэтгэмжийн даатгал	2,139,440.79	2,555,214.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,673,152.74	1,983,691.26
210204	Ажилгүйдлийн даатгал	418,288.19	495,926.80
210205	Эрүүл мэндийн даатгал	4,182,880.86	4,959,227.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,510,000.00	10,009,642.66
210301	Гэрэл, цахилгаан	5,238,279.32	3,447,900.27
210302	Түлш, халаалт	2,868,715.61	2,900,700.00
210303	Цэвэр, бохир ус	1,432,605.07	1,706,142.39
210304	Байрны түрээс	41,970,400.00	1,954,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,735,750.00	14,259,750.00
210401	Бичиг хэрэг	1,967,750.00	2,674,200.00
210402	Тээвэр, шатахуун	3,036,000.00	9,399,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	505,700.00	444,200.00
210404	Ном, хэвлэл	515,950.00	402,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	710,350.00	1,340,100.00
2105	Нормативт зардал	396,000.00	2,508,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,000.00	2,508,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,041,900.00	3,993,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,407,500.00	465,000.00
210604	Урсгал засвар	634,400.00	3,528,100.00

2107	Томилолт, зочны зардал	1,604,500.00	5,395,300.00
210702	Дотоод албан томилолт	1,604,500.00	5,395,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,269,560.00	2,334,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	721,060.00	1,785,750.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	346,500.00	346,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	202,000.00	202,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,323,369.00	14,061,949.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	93,608,073.00	14,061,949.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	627,117,166.69	599,548,745.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,947,251.00	33,726,978.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,903,500.00	3,831,360.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,703,505.00	5,307,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,340,246.00	24,588,018.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	147,723.99	1,663,056.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	147,723.99	1,663,056.08
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	458,192,952.70	484,760,411.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	458,192,952.70	484,760,411.34
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	146,829,239.00	79,398,300.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	146,829,239.00	69,000,000.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	10,398,300.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>4,563,767.43</u>	<u>8,116,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	11,488,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	11,488,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	11,488,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	11,488,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	<u>-11,488,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	4,563,767.43	-3,372,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,556,932.57	6,120,700.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,120,700.00	2,748,700.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,706,338.05	2,004,601.28	-110,123,550.63	82,587,388.70
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190,706,338.05	2,004,601.28	-110,123,550.63	82,587,388.70
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-2,889,827.77	-2,889,827.77
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,706,338.05	1,375,926.71	-127,777,505.26	64,304,759.50
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,706,338.05	1,375,926.71	-127,777,505.26	64,304,759.50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,299,755.38	1,299,755.38
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190,706,338.05	1,375,926.71	-126,477,749.88	65,604,514.88
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	1,299,755.38	00.00	-1,299,755.38
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-2,642,871.76	-2,642,871.76
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,706,338.05	76,171.33	-129,120,621.64	61,661,887.74

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	352,256,800.0 0	349,493,386.5 8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	352,256,800.0 0	349,493,386.5 8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	325,731,800.0 0	322,969,768.5 8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	246,735,400.0 0	246,701,398.5 4
210101	Үндсэн цалин	176,887,600.0 0	160,809,742.1 5
210102	Нэмэгдэл	51,121,200.00	59,203,359.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,890,200.00	17,551,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,836,400.00	9,136,897.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,309,300.00	31,713,377.50
210201	Тэтгэврийн даатгал	23,439,800.00	21,719,318.11
210202	Тэтгэмжийн даатгал	2,467,400.00	2,555,214.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,973,900.00	1,983,691.26
210204	Ажилгүйдлийн даатгал	493,500.00	495,926.80
210205	Эрүүл мэндийн даатгал	4,934,700.00	4,959,227.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,110,000.00	10,009,642.66
210301	Гэрэл, цахилгаан	4,221,600.00	3,447,900.27
210302	Түлш, халаалт	2,900,700.00	2,900,700.00
210303	Цэвэр, бохир ус	2,032,800.00	1,706,142.39
210304	Байрны түрээс	1,954,900.00	1,954,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,857,600.00	13,857,500.00
210401	Бичиг хэрэг	2,674,200.00	2,674,200.00
210402	Тээвэр, шатахуун	9,399,100.00	9,399,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	444,200.00	444,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,340,100.00	1,340,100.00
2105	Нормативт зардал	396,000.00	396,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,000.00	396,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	286,100.00	286,100.00
210604	Урсгал засвар	286,100.00	286,100.00
2107	Томилолт, зочны зардал	5,404,500.00	5,395,300.00
210702	Дотоод албан томилолт	5,404,500.00	5,395,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	570,900.00	548,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	346,500.00	346,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	202,000.00	202,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14062000.00	14061949.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,062,000.00	14,061,949.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26525000.00	26523618.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,525,000.00	26,523,618.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,936,900.00	1,935,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,588,100.00	24,588,018.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	352,256,800.0 0	349,493,386.5 8

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	340,860,700.0 0	339,197,643.9 2
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	340,860,700.0 0	339,197,643.9 2
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11,396,100.00	10,295,742.66
132001	Орон нутгийн төсвөөс	11,396,100.00	10,295,742.66
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	6,120,700.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	2,748,700.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	23.00	21.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	18.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7-р зүйлийн 7.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Д.Цолмон танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, төсвийг зохистой удирдах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 26-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор В.Жавзмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 22-ны өдрийн 52 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Газрын харилцааны чиглэлээр:

- Газрын тухай багц хуулийн хэрэгжилтийг орон нутагтаа зохион байгуулах
- Монгол Улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах
- Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх
- Газартай холбоотой аливаа асуудлаар аймгийн Засаг дарга, холбогдох бусад байгууллага, иргэдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх
- Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон тухайн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулах, ИТХ-аар хэлэлцүүлж батлуулах, хэрэгжилтийг хангуулах
- Аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд санал өгөх
- Аж ахуйн зориулалтаар газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах
- Аймгийн Засаг даргын шийдвэрийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмших гэрээ байгуулан, гэрчилгээ олгох, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэх
- Газар ашиглагч, эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газрын төлбөрийн ногдуулалт хийх, газрын төлбөрийн гэрээ байгуулж, дүгнэх
- Газрын тухай хууль зөрчсөн үйлдлийг илрүүлэх, зөрчил арилгах тухай мэдэгдэл өгөх, зөрчил арилгуулах талаар хууль хяналтын байгууллагад хандах
- Геодезийн цэг тэмдэгтийн өтгөрүүлэх, сэргээн засах ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагаар хийлгэх ажлыг зохион байгуулах
- Газрын кадастрын мэдээллийн санг хөтлөх, мэдээллийн баяжилтыг тухай бүр нь хийх, кадастрын мэдээллийн сангийн зураглалаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үйлчлэх

- Газрын тухай хуульд заасны дагуу кадастрын зураглал хийх тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээ байгуулан кадастрын зураглал хийлгэх, зураглалын ажилд нь хяналт тавих
 - Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэдэд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулах
 - Газар өмчлөгч иргэдэд газрын татвар ногдуулах
 - Газрын тухай багц хуулийг сурталчлах, тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулах
 - Газартай холбоотой мэдээ, судалгаа, тайлан, биелэлтийг гаргаж холбогдох дээд байгууллагад хүргүүлэх
2. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлээр:
- Барилга, дэд бүтэц, нийтийн аж ахуйн стандарт, норм дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих
 - Барилга байгууламж барих, засварлах, өргөтгөх, шинэчлэх ажлын гүйцэтгэлд зураг төслийн дагуу техник хяналт тавих
 - Барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналтыг гүйцэтгүүлэх
 - Хот байгуулалт, суурьшлын бүсийн хэтийн болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад санал оруулах, хэрэгжилтийг хангуулах
 - Гудамж, талбайн нэр, барилга байгууламжийн дугаар тогтоох
 - Барилгын зураг төсөл батлах, зөвшөөрөлцөх
 - Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын болон техникийн комисст ажиллах
 - Зургийн байгууллагуудад дэвсгэр зураг гарган өгч, ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан батлах
 - Барилгын зураг төсөл, хайгуул, барилга угсралт, барилгын материалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгах, хүчингүй болгох саналыг судлах, холбогдох дээд газарт уламжлах
 - Хотын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах үе шатны ажил, шинээр барьж байгуулах дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний төлөвлөлт, тооцоог гаргах
 - Барилга, хот байгуулалтын жижүүрийн зураг хөтлөх, иргэдэд мэдээллээр үйлчлэх
 - Байршлын схем зураг гаргаж өгөх
 - Зургийн даалгавар боловсруулах
 - Хотын инженерийн шугам сүлжээний мэдээллийн сан хөтлөх, шаардлагатай мэдээллээр иргэдэд мэдээлэл лавлагаа гаргаж өгөх
 - Тусгай зөвшөөрөлтэй байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих
 - Тусгай зөвшөөрөлтэй байгууллага, аж ахуйн нэгжүүдээс мэдээ, тайлан, судалгаа авч нэгтгэн холбогдох дээд газарт хүргүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгаль орчин аялал жуулчлалын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 511,221.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,112.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд жилийн нийт орлого 955,274.2 мянган төгрөг болж өссөн тул түүний 1 хувиар буюу 9,552.7 мянган төгрөг болгон өөрчилсөн болно.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,599.5 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,120.7	2,748.7	-3,372.0
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	15,157.9	13,717.5	-1,440.4
Үндсэн хөрөнгө	43,026.2	45,195.7	2,169.5
Нийт хөрөнгө	64,304.8	61,661.9	-2,642.9
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	64,304.8	61,661.9	-2,642.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	64,304.8	61,661.9	-2,642.9

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 6,120.7 мянган төгрөг нь ахмадын сангийн харилцах дансны үлдэгдэл бөгөөд тайлант онд 3,372.0 мянган төгрөгөөр буурсан байна

Бараа материалын дансны үлдэгдэл 1,440.4 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны бичиг хэргийн нөөцөөс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал бүртгэгдээгүй байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,169.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 22,492.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шинээр нэмэгдэж, тайлан онд байгуулсан хуримтлагдсан элэгдэл 20,322.5 мянган төгрөгийн зөрүүгээс шалтгаалсан байна.

Тайлант онд авлага, урьдчилгаа, өр төлбөрийн данснууд үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,642.9 мянган төгрөгөөр буурсан нь акталсан үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ болон тайлант оны хуримтлагдсан үр дүнгээс шалтгаалсан байна.

Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 114,312.7 мянган төгрөгөөр буюу 10.7 хувиар буурчээ.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг хэмжээгээр өөрчлөгдсөн нь үндсэн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 66,893.0 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого 107,656.0 мянган төгрөгөөр тус тус буурч, үндсэн үйл ажиллагааны санхүүжилт 60,236.4 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 113,667.1 мянган төгрөгөөр буюу 10.6 хувиар буурчээ. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй зардлуудыг авч үзвэл үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 10,857.6 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 75,865.8 мянган төгрөгөөр, тогтмол зардал 40,015.5 мянган төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалсан байна. Харин цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 39,005.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд акталсан үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ болох 1,299.8 мянган төгрөгийн бууралт, нягтлан бодох бүртгэлийн залруулга бүртгэсэн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 432,062.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 432,062.6 мянган төгрөгөөр тооцон, 2019 оны батлагдсан төсвийг 53 хувиар нэмэгдүүлэн төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 91,201.8 мянган төгрөгөөр бууруулж 340,860.7 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төсөлд тусгасан цалин хөлс, НДШ-ийн зардлаас 35,685.5 мянган төгрөг, эд хогшлын зардлаас 48,391.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хураамжийн зардлаас 3,518.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 6,567.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 352,256.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 340,860.7 мянган төгрөгийг улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээс, 11,396.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр, улсын төсөвт 64,000.0 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 460,041.9 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 340,860.7 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 11,396.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл үйл ажиллагаандаа 349,493.4 мянган төгрөгийг зарцуулж, 2,763.4 мянган төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 4,000.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 24,718.5 мянган төгрөгөөр тус тус давуулсан бөгөөд газрын дуудлага худалдаанаас шалтгаалсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 349,943.4 мянган төгрөг буюу 99.15 хувьтай байгаа нь ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1,595.9 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,100.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон барилгын материалын лабораторийн шинжилгээний төлбөрийн орлого 10,441.5 мянган төгрөгийн, Барилгын хөгжлийн төвөөс улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлын техник хяналт хийх гэрээний орлого 19,501.4 мянган төгрөгийн орлого төвлөрчээ.

Эд хогшил худалдан авахад 19,495.0 мянган төгрөгийг зарцуулж, ГЗБГЗЗГ-т 10,398.3 мянган төгрөгийг төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 147 мэдээлэл хугацаанд нь мэдээлж, 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6.10-р зүйлд заасны дагуу ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдүүлэг, байгууллагын даргын тушаалаар төсөв, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбогдон гарсан тушаал шийдвэрийг тухай бүр байршуулсан байна. аагүй. Хуулийн 6.4.5 заалтын дагуу 5.0 сая төгрөгөөс дээш дүн бүхийн орлого зарлагын гүйлгээг мэдээлэх хугацаанд нь мэдээлж хэвшсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тээвэр шатахууны зардал, үр дүнгийн урамшуулал, анхан шатны баримтгүй зарцуулалтад 3 албан шаардлага хүргүүлсэн алдааг давтан гаргахгүй ажилласан байна.

Цалингийн зардлын хэмнэлт, ур чадварын нэмэгдлийг үндэслэлгүй шийдвэрээр олгосон алдаанд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллажээ.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага	3	18,899.2	3	18,899.2			
Зөвлөмж	2		2				
Нийт дүн	5	18,899.2	5	18,899.2			

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 44,445.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 454.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 43,990.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүлэв.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 44,445.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 454.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант онд 15 ажилтан томилсон байх ба цалингийн шатлал тогтоосон байдалд сорил хэрэгжүүлэхэд 2 ажилтны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнээгүй байтал цалингийн шатлал алгасуулж, цалин тогтоосон байна. Энэ нь Засгийн газрын 218 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, баталгаажуулах, төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах, албан хаагчийн гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 4.14-т “нэгжийн даргаас албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг үндэслэн байгууллагын үнэлгээний баг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт болон байгууллагын дотоод журмыг баримтлан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар эрх бүхий этгээдэд санал гаргана”, 4.14.1.г-д “А буюу Маш сайн” үнэлгээ авсан төрийн албан хаагчийн хувьд цалингийн шатлалыг алгасуулж нэмэгдүүлэх (3 удаа дараалан “А буюу маш сайн” үнэлэгдвэл) гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 43,990.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын бараа үйлчилгээний бусад зардлын эрх зүйн үндэслэл, төлөвлөлт, зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн харьцуулахад бодитой, үнэн зөв төлөвлөдөггүй байна. Төсвийн төлөвлөлтөд бараа үйлчилгээний бусад зардалд 19,204.0 төгрөг төлөвлөхдөө холбогдох дээд шатны захирагчийн тушаалын дагуу төлөвлөсөн гэх боловч тооцоо судалгааны нотлох баримт байхгүй байна. Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг албан хаагчийн тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг харгалзахгүйгээр төлөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 46.3-т “хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагч нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц төрийн албанаас чөлөөлөгдөх, эсхүл төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацаанд ажиллах хүсэлтээ гаргана. Уг хүсэлтийг тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан хүлээн авч төрийн албанаас чөлөөлөх, эсхүл түүний үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, туршлага, эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацаанд үргэлжлүүлэн ажиллуулах шийдвэр гаргана. Төрийн жинхэнэ албан хаагч тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц болон төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэл үргэлжлүүлэн ажиллуулахаар тогтоосон хугацаа дуусмагц төрийн албанаас чөлөөлөгдөх тухай хүсэлтээ гаргаагүй нь захиргааны санаачилгаар түүнийг төрийн албанаас чөлөөлөхөд саад болохгүй” гэж заасантай нийцэхгүй байна.

Салбарын баярын бичгээр шагнуулсан 2 албан хаагчид "салбарын тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнуулсантай дүйцэхүйц мөнгөн шагнал олгосон байна. Тус байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 10.5-д “байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан албан хаагчийг 100000-300000 төгрөгөөр шагнаж урамшуулна” гэж заасны дагуу олгожээ. Уг дотоод журамд төрийн одон медаль, салбарын шагналаар шагнуулсан тохиолдолд олгох мөнгөн шагнал, урамшууллын хэмжээ тодорхойгүй байх тул холбогдох хууль эрх зүйн актуудад нийцүүлэн тодорхой тусгах шаардлагатай байна.

1.2 Эрсдэл: Төсвийн үргүй зардал өсөх, албан хаагчид тооцоолоогүй нөхцөл үүсэх, ашиг сонирхлын тэгш бус байдал үүсэх.

1.3 Өгсөн зөвлөмж: Байгууллагын дотоод журамд төрийн одон медаль, салбарын шагналаар шагнуулсан тохиолдолд олгох мөнгөн шагнал, урамшууллын хэмжээг холбогдох хууль эрх зүйн актуудад нийцүүлэн тодорхой тусгах. Төсвийг төлөвлөхдөө Төсвийн тухай хууль, холбогдох журамд нийцүүлэн, тооцоо судалгаатайгаар эрсдэл үүсгэхгүй байхаар үнэн зөв төлөвлөх.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Орхон аймгийн ГХБХБГ-ын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 236 тоот албан бичгээр зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

2.Балансын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Тайлант онд 9,001.0 мянган төгрөгийн шатахуун олгож, жолоочийн тооцооны хуудас хөтөлсөн байна. Жолоочид шатахуун олгохдоо шатахуун зарцуулалтын нормыг хөдөлгөөний эрчим ихтэй Улаанбаатар хотын замд тооцсон жишиг нормоор тооцжээ. Жолоочийн тооцоо бодохдоо спидометрийн заалттай тулгаагүйгээс 410.0 мянган төгрөгийн зөрүү үүссэнийг хянаагүй байна. Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны

Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

390 дүгээр тушаалаар баталсан автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормтой нийцэхгүй ба автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлалыг авто тээврийн хэрэгсэл бүхийн ААНБ, иргэд шатахуун зарцуулалтын нэгжийн норм, хэрэгцээг төлөвлөх, тогтоох, нэмэгдүүлэх, хоргодуулах, шатахуун зарцуулалтын хэмжилт туршилт хийхэд ашиглаж болохоор заасан байтал мөрдөөгүй, хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

2.2. Эрсдэл: Төсвийн үрэлгэн зардал өсөх, дотоод хяналт алдагдах.

2.3. Өгсөн зөвлөмж: Автомашины шатахууны норм, зарцуулалтын тооцоог холбогдох дүрэм, аргачлалд нийцүүлэн үнэн зөв тооцож, дотоод хяналтыг сайжруулах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Орхон аймгийн ГХБХБГ-ын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 236 тоот албан бичгээр зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Гурав. Баталгаажуулалт:

Тайлан бэлтгэсэн:

Ахлах аудитор

В.ЖАВЗМАА

Анхан шатны чанарын хяналт хийсэн:
Аудитын менежер

Б.ЭРДЭНЭ

Хоёр дах шатны чанарын хяналт хийсэн:

Дарга, тэргүүлэх аудитор

Ц.НАРМАНДАХ



Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021	Аудитын нэр: Орхон аймгийн ГХБХБГазрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ОРА-2021/6/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд шинээр томилсон 2 ажилтны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнээгүй байтал цалингийн шатлал алгасуулж, цалин тогтоосон.	454.8	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Д.Цолмон Б.Ариунцэцэг
2	Шатахуун зарцуулалтын нормыг хөдөлгөөний эрчим ихтэй Улаанбаатар хотын замд тооцсон жишиг нормоор тооцож, тооцоо бодохдоо спидометрийн заалттай тулгаагүйгээс зөрүү үүссэнийг хянаагүй байна.	401.2	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Д.Цолмон Б.Ариунцэцэг
3	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн харьцуулахад бодитой, үнэн зөв төлөвлөдөггүй байна. Төсвийн төлөвлөлтөд бараа үйлчилгээний бусад зардалд 19,204.0 төгрөг төлөвлөхдөө холбогдох дээд шатны захирагчийн тушаалын дагуу төлөвлөсөн гэх боловч тооцоо судалгааны нотлох баримтгүй, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг албан хаагчийн тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг харгалзаагүй байна. Салбарын баярын бичгээр шагнуулсан 2 албан хаагчид "салбарын тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнуулсантай дүйцэхүйц мөнгөн шагнал олгосон байна.	43,589.7	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Д.Цолмон Б.Ариунцэцэг
ДҮН		44,445.7			

Гурав. Баталгаажуулалт:

Тайлан бэлтгэсэн:

Ахлах аудитор

В.ЖАВЗМАА

Анхан шатны чанарын хяналт хийсэн:

Аудитын менежер

Б.ЭРДЭНЭ

Хоёр дах шатны чанарын хяналт хийсэн:

Дарга, тэргүүлэх аудитор

Ц.НАРМАНДАХ

